



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 2/124

Цагаантолгой

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, аймгийн Засаг даргын “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” 2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн А/390 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хугацаат цэргийн албаны 2022 оны хоёрдугаар ээлжийн татлага эхэлсэнтэй холбогдуулан сумын хэмжээнд бэлтгэл байдлыг хангах, зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: А.Одхүү (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Л.Сэлэнгэсайхан (Ивэн 1-р багийн Засаг дарга)

Б.Золбаяр (Хушаат 2-р багийн Засаг дарга)

Ч.Азжаргал (Төрийн захиргаа, хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Ц.Сонинзул (Улсын бүртгэгч)

Э.Очгэрэл (Эрүүл мэндийн төвийн дарга)

Ч.Лхагважаргал (Цагдаагийн хэсгийн төлөөлөгч)

2. Хугацаат цэргийн албаны 2022 оны хоёрдугаар ээлжийн татлагад 1996-2004 онд төрсөн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулсугай.

3. Хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудад нэг бүрчлэн зарлан дуудах хуудас гардуулан өгч, цэрэг татлагын байранд заасан хугацаа, тогтоосон цагт бэлэн байлгах, бичиг баримтын бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт орж байгаа иргэдэд цусны ерөнхий, шээсний ерөнхий, биохимийн, элэгний В,С вирус илрүүлэх, ДОХ, тэмбүүгүйн түргэвчилсэн шинжилгээ хийхэд шаардагдах эмнэлгийн багаж хэрэгсэл, эмч мэргэжилтний бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Э.Очгэрэл)-д даалгасугай.

Боловсруулсан: Д. Оюун
Хянасан: Ч. Азизов
Хувь: 2

5. Цэрэг татлагад хамрагдах залуучуудыг нэгдсэн журмаар цэрэг татлагын байранд хүргэх, тээвэрлэх явцад аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, цэрэг татлагын өдрүүдэд согтууруулах ундаа худалдаалахгүй, түүгээр үйлчлэхгүй байхад хяналт тавьж хэв журам сахиулахыг сумын хэсгийн төлөөлөгч (Ж.Лхагважаргал)-д үүрэг болгосугай.

6. Цэрэг татлагын бэлтгэл ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, үр дүнтэй зохион байгуулах, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг бүрэн хамруулах, халдвар хамгааллын дэглэмийг сайтар мөрдүүлж, ажлын үр дүн, биелэлтийг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР